

БАТЛАВ.

УБЦТС ТӨХК-ИЙН ТЕХНИКИЙН АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ Л. ГАНЗОРИГ

**БИОСКО Б-120Т урьдчилан үйлдвэрлэсэн дэд өртөөнд өгөх
техникийн даалгавар №**

Огноо: 2015-04-23

1. **Үйлдвэрлэгчийн нэр, хаяг:** Хан Уул дүүрэг, “Гутал” ХХК-ны байр, 306 тоот “Эрчим Инженеринг” ХХК
2. **Хэрэглэгчийн байршил:** Орон сууцны барилга, хороолол, үйлдвэр, аж ахуйн газруудад
3. **Тоног төхөөрөмжийн зориулалт:** Орон сууцны барилга, хороолол, үйлдвэр, аж ахуйн 6(10)/0,4кВ-н цахилгаан хангамж.
4. **Техникийн даалгавар олгох үндэслэл:** ЭХЯ-ны 2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1/270 тоот албан бичиг
5. **Тоног төхөөрөмжийн суурилагдсан чадал:** Тус бүр нь 1250 кВА хүртэл чадал бүхий 1 эсвэл 2 трансформатортай.
6. **Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:**

БИОСКО Б-120Т маягийн урьдчилан үйлдвэрлэсэн төмөр бетон хийцтэй дэд өртөө нь Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудын шаардлагуудыг хангахаас гадна доорх шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

 - 6.1. “Эрчим Инженеринг” ХХК-ын үйлдвэрлэх БИОСКО Б-120Т маягийн дэд өртөө нь олон улсын цахилгаан техникийн хорооны IEC62271-202 стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай.
 - 6.2. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөө нь урьдчилан үйлдвэрлэсэн төмөр бетон хийц бүхий барилгатай байна.
 - 6.3. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөнд 6/0.4 кВ эсвэл 10/0.4 кВ-ын 1250 кВА хүртэл чадалтай 1 эсвэл 2 трансформатор суурилуулна.
 - 6.4. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөний 6(10) кВ-ын хуваарлах байгууламжийг элегаз (SF₆) тусгаарлага бүхий компакт ячейкаар тоноглоно.
 - 6.5. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөө нь 1 болон 2-р зэрэглэлийн хэрэглэгчидийг тэжээх бол өндөр ба нам талдаа 2 секцтэй байна. Өндөр ба нам талуудын секц тус бүр нь уг дэд өртөөний хэрэглээг дангаараа бүрэн хангахуйц чадалтай байх шаардлагатай.
 - 6.6. Дэд өртөөний 6(10)кВ-ын хуваарлах байгууламж нь 2 секцтэй бол секц холбогч таслах залгах аппараттай байх шаардлагатай. Секц холбогч таслах залгах аппаратын хэвийн гүйдэл нь 6(10)кВ-ын оруулга, гаргалгуудын таслах залгах аппаратын хэвийн гүйдлийн хэмжээтэй тэнцүү байна.
 - 6.7. Хэрэв БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөг орон сууцны хороолол хотхоны цахилгаан хангамжид ашиглах бол 6(10)кВ-ын хуваарлах байгууламж нь 2 секцтэй байх ёстой ба 6(10)кВ-ын секц тус бүрдээ секц холбогчоос гадна хамгийн цөөндөө оруулга шугамын 1, гаргалга шугамын 2, трансформаторын 1 ячейкатай байх ёстой.

6.8. Хэрэв БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөг орон сууцны хороолол хотхоны цахилгаан хангамжид ашиглах бол 0.4 кВ-ын хуваарлах байгууламж нь 2 секцтэй байх ёстой ба 0.4 кВ-ын секц тус бүрдээ 250А, 400А, 630А хэвийн гүйдэл бүхий 10-аас доошгүй эсвэл 250А-аас бага хэвийн гүйдэл бүхий 20-оос доошгүй гаргалга групп тоноглогдсон байна. Тухайн тодорхой дэд өртөөн дэх гаргалгын тоо, хэвийн гүйдлийн хэмжээг энэхүү заалтыг мөрдлөг болгон зураг төсөл зөвшилцөх шатанд тодорхойлно.

6.9. Дэд өртөөний 0,4кВ-ын хуваарлах байгууламж нь 2 секцтэй бол секц холбогч автомат (эсвэл рубильник)-тай байх шаардлагатай. Секц холбогч автомат (эсвэл рубильник)-ын хэвийн гүйдэл нь трансформаторын 0,4кВ-ын оруулгын автоматын хэвийн гүйдлийн 70%-аас багагүй хэмжээтэй байна.

6.10. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөө нь өндөр ба нам талдаа 2 секцтэй бол өндөр ба нам талуудын хуваарилах байгууламжуудыг тус тусад нь ерөөнд байрлуулсан байна.

6.11. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөө нь гадна талаасаа орчныхоо архитектурт уусч нийцсэн өнгө, үзэмж, засал, хийцтэй байх ёстой. Дээврийн ус хаалгатай хана талруу урсахааргүй байх ёстой.

6.12. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөний кабелийн давхар шалны өндөрийн цэвэр зай 1м-1.2м байх ба хүн орж ажиллах хэсгийн өргөн нь 1м-ээс багагүй байх ёстой.

6.13. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөний дотор суурилагдсан тоног төхөөрөмжүүд, түүний эд ангиуд нь -40°C хүртэл температурт ажиллах зориулалтгүй бол тухайн суурилагдсан тоног төхөөрөмжүүд, түүний эд ангиудын ажиллах хэвийн орчныг бүрдүүлэх халаагуур суурилуулсан байх шаардлагатай. Халаагуур нь температурын датчиктай байх ёстой бөгөөд шаардлага гарсан үед өөрөө автоматаар асаж, унтардаг байх ёстой.

6.14. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөний трансформаторын өрөөний хаалга нь зуны улиралд өрөөн доторхи дулаан солилцоог хангах салхивчуудтай байх ёстой. Салхивчны нүхний өргөн нь 10мм-ээс ихгүй байна. Салхивч нь босоо тэнхлэгт 60° үүсгэн орж буй борооны дусал орохооргүй, мөн 50мм-ээс урт нарийн төмөр утас эгцээрээ орохооргүй хийцтэй байх ёстой.

6.15. БИОСКО Б-120Т маягийн дэд өртөөний хаалгануудын битүүмжлэл нь (трансформаторын өрөөний салхивчыг тооцохгүйгээр) IEC-60529 стандартын IP-42 шаардлагыг хангасан байх ёстой.

7. Энэхүү техникийн даалгаварыг УБЦТС ХК-ийн зүгээс тухайлсан цэгт холбогдох хэрэглэгч бүрт олгох ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ болон УБЦТС ХК-ийн батлан гаргасан ТЕХНИКИЙН ШААРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ-уудтай хамтатган хэрэглэнэ.